



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/89

Хэрлэн сум

Цахим систем нэвтрүүлэх ажлын хэсэг байгуулах, зохион байгуулалтын арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4.5 дахь заалтын "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно" гэснийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системийг нэвтрүүлэх ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системийг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөг дагаж мөрдөх, төлөвлөсөн хугацаанд багтаан нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэг, сумдын Засаг дарга, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системийн шилжилтийн программд 2024 оны жилийн эцсийн байдлаарх хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөн, санхүүгийн тайлан мэдээг 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор, 2025 оны эхний хагас жилийн тайланг 2024 оны тайлан баталгаажсаны дараа үнэн зөв, бүрэн оруулахыг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, эрхлэгч, захирал нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэл, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





۲۵۴۴ ۲۵ ۵۵

Handwritten signature: *Book*

۴۴. سکه مهرن

محمد مصطفیٰ



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

Нарийн бичгийн
дарга:

Гишүүд:

Аймгийн Засаг даргын орлогч

Орон нутгийн өмчийн газрын дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Автотээврийн төвийн дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Боловсролын газрын дарга

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын дарга

Татварын газрын дарга

Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 13-ний өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах, хамтран ажиллах байгууллага
2025 оны 01 сарын 13-ний өдрөөс 03 сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд Шилжилтийн системийг ашиглан суурь мэдээллийн санг бүрдүүлэх, Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд шилжих бэлтгэл ажлыг хангах			
1	Шилжилтийн системийг ашиглах сургалтыг Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой бүх хуулийн этгээдэд зохион байгуулах /танхимаар болон цахимаар/	02-р сарын 25-ны өдрөөс өмнө	ОНӨГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
2	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой бүх хуулийн этгээдүүд хөрөнгийн хөдөлгөөний мэдээллээ шилжилтийн системд оруулж эхлэх	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
3	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой бүх хуулийн этгээдийн дэлгэрэнгүй бүртгэлийг нягталж, Улсын бүртгэлийн хэлтэстэй тулгах	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Улсын бүртгэлийн хэлтэс, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
4	Барилга, байгууламжийн бүртгэлийг барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн бүртгэл гэж 3 салгах, мэдээллийг бүрэн оруулах, нягтлах	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ГХБХБГ, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
5	Газрын бүртгэлийг E-GAZAR цахим системтэй тулгах мэдээллийг бүрэн оруулах нэгж талбарын дугаарыг нягтлах,	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ГХБХБГ, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
6	Тээврийн хэрэгслийн бүртгэлийг VRS-Transdep цахим системтэй тулгах мэдээллийг бүрэн оруулах Улсын дугаар, арлын дугаарыг нягтлах	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Авто тээврийн төв, Татварын газар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой

			хуулийн этгээд
7	Машин тоног төхөөрөмжийн бүртгэлийг МТТ (үйлдвэрлэл, тусгай зориулалтын тоног төхөөрөмж), Оффисын жижиг тоног төхөөрөмж (компьютер түүний дагалдах хэрэгсэл) Батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмж гэж 3 салгах, мэдээллийг бүрэн оруулах нягтлах, багцалж нэг бүртгэсэн бүртгэл байвал задалж бүртгэх	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
8	Тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэлээс Номын фондыг салгах, мэдээллийг бүрэн оруулах нягтлах, багцалж нэг бүртгэсэн бүртгэл байвал задалж бүртгэх	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Боловсролын газар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
9	Бүх биет үндсэн хөрөнгийн бодит 4 хүртэлх зураг оруулах, биет бус хөрөнгийн лиценз, гэрээ, гэрчилгээ, программын цонхны зураг зэргийг оруулах (одоогийн байдлаарх)	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
10	2024 оны хөрөнгийн хөдөлгөөнийг 2025 оны 03 сарын 31-ний өдрөөс өмнө, 2025 оны хөрөнгийн хөдөлгөөнийг 05 сарын 30-ний өдрөөс өмнө цахим системд оруулсан байх	2024 оны хөрөнгийн хөдөлгөөн 03-р сарын 31-ны өдрөөс өмнө, 2025 оны хөрөнгийн хөдөлгөөн 05-р сарын 30-ний өдрөөс өмнө	ОНӨГ, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
11	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн Хувьцаа эзэмшигчийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын удирдлагын модуль бэлэн болсон байх /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
12	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн судалгаа гаргах модулийн мэдээлэл бэлэн болсон байх 1. ТУЗ-ын гишүүдийн судалгаа 2. Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны судалгаа 3. Хуулийн этгээдээс тухай бүрд нь	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани

	динамик байдлаар авах судалгаа 4. Хуулийн этгээдийн хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа 5. Хэрэглэгчийн санал асуулга /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/		
13	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалт, нөөц бүрдүүлэх модулийн мэдээлэл, шалгуур үзүүлэлт, холбогдох мэдээлэл бэлэн болсон байх /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
14	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт, шалгалтын модулийн мэдээлэл, асуулга, сургалтын материал мэдээлэл бэлэн болсон байх. /А. Компанийн засаглалын сургалт, шалгалт, Б. Санхүү, эдийн засгийн төлөвлөлт, түүнд дүн шинжилгээ хийх В. ТӨБЗГ болон бусад байгууллагаас зарласан сургалтууд давхар цахимаар үзэх боломжтой байх/ /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
15	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг тайлагнах модулийн мэдээлэл бэлэн болсон байх /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
16	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Зорилтын саналын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг дүгнэх модулийн мэдээлэл бэлэн болсон байх. Зорилтот түвшин, Хөрөнгө оруулалт, аудитлагдсан санхүүгийн тайлангаас автоматаар таталт хийн дүгнэдэг байх /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
17	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн жил бүрийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг төлөвлөх, түүний хэрэгжилтийг дүгнэх модулийн мэдээлэл бэлэн болсон байх /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
18	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн жил бүрийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, шинэчлэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хангах, дүгнэх, үр дүнг нийтлэх модулийн холбогдох мэдээлэл бэлэн шалгуур үзүүлэлт мэдээлэл бэлэн болсон байх /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани

19	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой бүх хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, түүний тодруулга тайланг /аудитаар баталгаажсан/ автоматаар татаж системд оруулсан байх. Санхүүгийн тайлангаас гадна хуулийн этгээдээс нэмэлтээр оруулах шаардлагатай бусад санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийг системээр илгээх боломжтой болсон байх /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
20	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэгтгэн дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийх модулийн мэдээлэл бэлэн болсон байх. зорилтын санал, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, санхүүгийн тайлангаас автоматаар таталт хийн, шинжилгээ хийдэг болсон байх. /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
21	Орон нутгийн өмчит Хуулийн этгээдтэй холбоотой санхүү, эдийн засгийн болон үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий цахим, динамик товхимлын мэдээлэл бэлэн болсон байх. /сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
22	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Файлын сангийн мэдээлэл үүсгэхэд бэлэн болсон байх. Үүнд: А. Хуулийн этгээдийн бүртгэл, үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүд Б. Хуулийн этгээдтэй холбоотой эрх бүхий дээд шатны байгууллага буюу УИХ, Засгийн газар, ИТХ, Засаг даргын шийдвэрүүд В. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоол, тэмдэглэлийн сан Г. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, тэмдэглэлийн сан Д. Аудитлагдсан санхүүгийн тайлан болон хууль журамд заасан нийтэд мэдээлбэл зохих бүх төрлийн мэдээллийн сан. /Тухайн хуулийн этгээдийг анх байгуулагдсанаас хойших бүх мэдээллийг бэлтгэнэ /	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
23	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Программын компани

	нэгтгэн удирдлага, зохицуулалтаар хангах зориулалт бүхий нэгдсэн дотоод удирдлагын панелийг үүсгэхэд шаардлагатай мэдээллийг бэлэн болсон байх.		
24	Хяналт шалгалтын төлөвлөгөө, хуваарь, удирдамж боловсруулах, шалгалтад хамрагдаж буй хуулийн этгээдэд удирдамж, тайлан хүргүүлэх явцын модуль бэлэн болсон байх, хамтран нягтлан шалгах /төлөвлөгөө, хуваарь, удирдамжийн загварыг программд хөрвүүлэх/	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, ОНӨААТҮГ, Хэнтий Ус ХХК, Программын компани
25	Цахим архив үүсгэх модуль бэлэн болсон байх	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Программын компани
26	Хяналт шалгалтын төлөвлөгөө гүйцэтгэл, илэрсэн зөрчил дутагдал /хуулиар болон мөнгөн дүнгээр/, хяналт шалгалтын төрлөөр хянах самбарыг бий болгох нэгдсэн мэдээллийг үзүүлэх панель бэлэн болсон байх, хамтран нягтлан шалгах	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Программын компани
27	Гүйцэтгэлийн хяналт шалгалтын загварыг программд хөрвүүлэх, хамтран нягтлан шалгах	03-р сарын 31-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Программын компани
2025 оны 04 сарын 20-ны өдрөөс 05 сарын 30 хүртэл хугацаанд 1 төсөвт байгууллага, 1 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар дээр туршилт хийх			
28	Систем нэвтрүүлэх туршилтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, илэрсэн алдаа дутагдлыг мэдээлэх	05-р сарын 30-ний өдрөөс өмнө	ОНӨГ, Программын компани
2025 оны 06 сарын 01-ний өдрөөс 07 сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой бүх байгууллагад сургалт хийх			
29	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтарч албан хаагчдад сургалт зохион байгуулах	07-р сарын 01-ны өдрөөс өмнө	ОНӨГ, ТӨБЗГ, Программын компани
2025 оны 07 сарын 01-ний өдрөөс систем Шинээр хийгдэж байгаа системийн Вакс-СЯНсе, Егон!-ОГПсе системийг нэвтрүүлэх.			
30	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой бүх хуулийн этгээдүүд Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим системийн дутуу мэдээллийн дүүргэлтийг хийх	07 сарын 01 - ний өдрөөс 09-р сарын 01-ний өдөр хүртэл	ОНӨГ, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд
31	Нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хяналт тавих, илэрсэн алдаа дутагдлыг мэдээлэх	09-р сарын 01-ны өдрөөс өмнө	ОНӨГ, Программын компани
32	Портал веб хуудас, Мобайл аппликэйшн нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах	09-р сарын 01-ны өдрөөс өмнө	ОНӨГ, Программын компани
2025 оны 09 сарын 1-ний өдрөөс Иргэд, Аж ахуйн нэгжид зориулсан портал систем нэвтэрч эхлэх			